



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/237

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5 дахь заалт, “Хөрөнгө зарцуулах тухай” Өвөрхангай аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/527 дугаар захирамжийн 3 дахь хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2023 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 15/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Мал, мах 2022” нэгдсэн арга хэмжээний хүрээнд эргүүл, постонд гарсан албан хаагчдын шатахууны зардалд 1,400,000 (нэг сая дөрвөн зуун мянга) төгрөг, хоолны зардалд 450,000 (дөрвөн зуун тавин мянга) төгрөг, цаг үеийн ажлаар хөдөөгүүр явах шатахууны зардалд 300,600 (гурван зуун мянга зургаан зуу) нийт 2,150,600 (хоёр сая нэг зуун тавин мянга зургаан зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 2,150,600 (хоёр сая нэг зуун тавин мянга зургаан зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН